



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ж.ХАТАНБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.13 № 02/112-ЧАГ-ГАГ/2013/02-ГА

Хариуцлага тооцуулах тухай

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санүүжүүлсэн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулиар 2012 онд хөрөнгө батлагдаагүй байхад Говийн бүсийн эмчилгээ, оношлогооны төвийн (Өмнөговь, Даланзадгад) барилгын зураг, төсөл хийх ажлыг 35.4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

Түргэн тусламжийн үйлчилгээг нийслэлийн иргэдэд ойртуулах зорилгоор дүүргүүдийн эрүүл мэндийн нэгдэлд гэмтлийн үеийн яаралтай тусламжийн нэгж байгуулахаар нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд гэмтлийн үед тусламж үзүүлэх яаралтай тусламжийн иж бүрдэл, гэмтэлийн чигүүд, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийн ХАА-г зохион байгуулахдаа 2 багц болгон харьцуулалтын аргаар Сүвэн уул ХХК-тай нийт 56.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

2012 оны Төсвийн тухай хуулийн 23.3.9-д нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж авахаар батлагдсан 250.0 сая төгрөгийн зардлын хэмнэлтээс Ньюсоник ХХК-тай 83.7 сая төгрөгийн гэрээ байгуулан сүлжээний тоног төхөөрөмж, Сүвэн-уул ХХК-тай 29.7 сая төгрөгийн гэрээг харьцуулалтын аргаар байгуулан гэмтлийн үеийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмж худалдан авчээ.

2012 онд зохион байгуулсан ХАА-ны зарим тендерийн материалыг архивт хүлээлгэж өгөөгүй, баримтын товъёог ойлгомжгүй, материалууд эмх цэгцгүй, цаг хугацааны дараалалгүй, баримтууд олон дахин давтагдсан эсвэл дутуу үдэгдсэн байна.

Дээрх үйл ажиллагаа нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 8.5-д “...босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох”, Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.25-д “...захиалагч байгууллага тендер шалгаруулалтын дүнд үүссэн хэмнэлтийг ашиглахыг зөвшөөрөхгүй”, 2007 оны 81 дүгээр тушаалын 2.3.2-т “...тухайн ХАА-тай холбоотой бүх баримт,

073157


материалыг бүрдүүлж, хавтаст хэрэг хөтлөх, баримтжуулж хадгалах” гэж заасныг тус тус зөрчжээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад хууль, журам зөрчсөн холбогдох албан тушаалтнуудтай ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу хариуцлага тооцох

2. Албан шаардлагын хэрэгжилтийг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Хатанбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Дамдиндорж нарт хариуцуулан албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлага бичсэн:

АУДИТОР  Б.САРУУЛ

УХА0122